

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/307

Номгон

Малын хагас жилийн түүвэр судалгаа
явуулах тухай

Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, "Малын индексжүүлсэн даатгалын тухай" хуулийн 6 дугаар зүйл 6.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2024 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын тооллогоор сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг сайтар хангаж хуулийн дагуу, ямар нэгэн зөрчилгүй, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, хяналт шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн, түүвэр судалгаанд сонгогдсон өрх нэг бүрээр цахим программын дагуу шивж оруулан нэгтгэлийг баг, сумын түвшинд гаргаж аймгийн Статистикийн хэлтэст 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан сумын түвшний нэгтгэл гарч, түүнд үндэслэн даатгалын нөхөн төлбөр олгодог тул мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг хангаж, мэдээллийг шивэх явцад гарч болзошгүй алдаа, нөхөн төлбөр олгох явцад гарах маргаан зэргээс урьдчилан сэргийлж, тооллогын ажилд хариуцлагатай хандахыг сумдын холбогдох албан тушаалтнуудад даалгасугай.

5. Малын түүвэр судалгааны ажилд зарцуулах 1,500,000.0 /Нэг сая, таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.


624010745

2.

6.Малын түүвэр судалгааны ажлыг аргачлал, маягт, заавраар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Статистикийн хэлтэс (Г.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

7.Малын түүвэр судалгааны ажлыг сумдад зохион байгуулан явуулж дүн нэгтгэлийг гаргаж Үндэсний Статистикийн Хороонд мэдээлэхийг аймгийн комисс (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2013 оны 25 дугаар
сарын 17-ны өдрийн 10 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга

Б.Батсуурь

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Б.Мөнхтогтох

Хүнс, хөдөө аж ахуйн даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Г.Ганчимэг

Статистикийн хэлтсийн дарга

Ч.Эрдэнэбат

Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Ариунбуян

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Энхбаяр

Баянхонгор сумын Засаг дарга

С.Энхтөр

Баацагаан сумын Засаг дарга

Д.Пүрэвсүрэн

Баянбулаг сумын Засаг дарга

Б.Бат-Амгалан

Баянговь сумын Засаг дарга

О.Мөнхбат

Баянлиг сумын Засаг дарга

Ж.Хатанбаатар

Баян-Овоо сумын Засаг дарга

Б.Идэрмөнх

Баян-Өндөр сумын Засаг дарга

Н.Гансүх

Баянцагаан сумын Засаг дарга

Л.Ганаа

Богд сумын Засаг дарга

М.Баярсайхан

Бөмбөгөр сумын Засаг дарга

Д.Лхагвадорж

Бууцагаан сумын Засаг дарга

А.Батбаяр

Галуут сумын Засаг дарга

Э.Жавхлан

Гурванбулаг сумын Засаг дарга

Д.Мөнхжаргал

Жаргалант сумын Засаг дарга

Р.Батжаргал

Жинст сумын Засаг дарга

М.Батбаяр

Заг сумын Засаг дарга

Т.Эрдэнэбат

Өлзийт сумын Засаг дарга

С.Сумъяабазар

Хүрээмарал сумын Засаг дарга


Б.Бат-Эрдэнэ

Шинэжинст сумын Засаг дарга

Д.Цэвэгдорж

Эрдэнэцогт сумын Засаг дарга

Аймгийн Засаг даргын 2017 оны 17-дугаар
сарын 17-ны өдрийн 1307 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ХЯНАЛТААР
СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ

Б.Батсуурь -Аймгийн Засаг даргын орлогч

Баацагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Баянцагаан

Г.Ганчимэг -Статистикийн хэлтсийн дарга

Жаргалант, Заг,Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал

Б.Мөнхтогтох -ХХААГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт

Ч.Эрдэнэбат - Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Баянлиг, Баянговь, Баян-Өндөр,

Шинэжинст

Д.Ариунбуян -Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Жинст, Богд

оОо